

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР


БОЛОН

“ЭС БИ ПЕТРОЛИУМ” ХХК-ИЙН

ХООРОНД БАЙГУУЛСАН

ЭРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

/ Сайнцагаан талбай/



ЭРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ

20¹⁸ оны ⁰⁸ дүгээр
сарын ⁰⁸-ны өдөр

Дугаар ^{18/06}

Улаанбаатар
хот


Нэг талаас Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Ашигт малтмал, газрын тосны газар (цаашид АМГТГ гэнэ)-ыг төлөөлж дарга Х.Хэрлэн, нөгөө талаас “Эс Би Петролиум” ХХК (цаашид Компани гэнэ) –ийг төлөөлж ерөнхий захирал С.Баттулга, нар (хамтад нь “Талууд” гэнэ) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож Монгол Улсын Газрын тосны тухай хуулийн 15 дугаар зүйлийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Талууд Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт сумдын нутаг дэвсгэрт хавсралт “Б”-д заасан талбайд “Шатдаг занар”-ын эрлийн ажлыг гүйцэтгэнэ.
- 1.2 Энэхүү гэрээ нь Газрын тосны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. НЭР ТОМЪЁО

- 2.1 “Эрэл” гэж тодорхой нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлвийг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг;
- 2.2 “Газрын тос” гэж газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд хатуу, шингэн, хийн төлөвт орших нүүрс-устөрөгчийн нэгдэл /түүхий тос, байгалийн хий/-ийг;
- 2.3 “Байгалийн хий” гэж газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд хийн төлөвт дангаар орших нүүрс-устөрөгчийн нэгдлийг;
- 2.4 “Уламжлалт бус газрын тос” гэж байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийтэй элс, хийтэй занар, нүүрсний давхаргын метан хийг;
- 2.5 “Нүүрсний давхаргын метан хий” гэж нүүрсжих явцад нүүрсэнд хуримтлагдсан хийг;
- 2.6 “Хүчин төгөлдөр болсон огноо” гэж гэрээг байгуулсан он, сар, өдрийг;
- 2.7 “Эрэл хийх нутаг дэвсгэр” гэж энэхүү гэрээний 1.1, хавсралт “Б”-д заасан талбайг;
- 2.8 “Эрлийн ажлын хөтөлбөр” (цаашид хөтөлбөр гэнэ) гэж гэрээний хугацаанд хийж гүйцэтгэх, энэхүү гэрээний В хавсралтад дурьдсан геологийн судалгааны ажлыг;



2.9 “Эрлийн ажлын төсөв” гэж эрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг;

2.10 “Оператор компани” гэж гэрээлэгчийн газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч компанийг;

2.11 “Туслан гүйцэтгэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэхээр гэрээлэгчтэй, эсхүл оператор компанитай гэрээ байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээдийг;

2.12 “Эрлийн ажлын тайлан, материал” гэж тухайн талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлвийг тогтоох зорилгоор гэрээг хэрэгжүүлэх явцад хийж гүйцэтгэсэн эрэл, судалгааны ажлын бүхий л мэдээлэл, тайлан материалыг;

2.13 “Гэрээ дуусгавар болсон огноо” гэж эрлийн ажил дуусгавар болж, Талууд гэрээг дүгнэн, энэхүү гэрээний 2.12 -д заасан материалыг Ашигт малтмал, газрын тосны газарт хүлээлгэн өгсөн он, сар, өдрийг хэлнэ.

Гурав. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Ашигт малтмал, газрын тосны газрын эрх

3.1.1 Тухайн жилд хийх эрлийн ажлын төлөвлөгөө, төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.1.2 Эрлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль эрх зүйн актын хэрэгжилтэнд хяналт тавина.

3.1.3 Эрлийн ажилд Ашигт малтмал, газрын тосны газраас холбогдох мэргэжилтнийг томилж ажиллуулна.


3.1.4 Ашигт малтмал, газрын тосны газраас томилогдсон мэргэжилтэн нь эрлийн үйл ажиллагаатай танилцах, оролцох, эрлийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавина.

3.1.5 Эрлийн ажил гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан эрлийн ажил, судалгааны бүхий л мэдээлэл, тайлан материал, баримт бичгийн нэг хувийг өмчилнэ.

3.2 Ашигт малтмал, газрын тосны газрын үүрэг

3.2.1 Эрлийн гэрээ байгуулсан талбайг эрлийн ажлын гэрээг дүгнэж албан ёсны шийдвэр гартал шатдаг занарын хайгуулын талбайгаар зарлахгүй.

3.2.2 Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан талбайн байршлын талаар орон нутгийн захиргаанд мэдэгдэнэ. Эрлийн ажил гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон нутгийн засаг захиргаа, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах, уулзалт зохион байгуулах, шаардлагатай зөвшөөрөл авах болон бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.



3.2.3 Ашигт малтмал, газрын тосны газрын өмчлөлд байгаа эрлийн ажил гүйцэтгэх талбайд хамаарах тайлан мэдээллээр хангаж, шаардлагатай бол холбогдох журмын дагуу бэлтгэж өгнө.

3.2.4 Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийн талаар УУХҮЯ-нд жил бүр тайлан гаргаж өгнө.

3.2.5 Компанийн эрлийн ажилд зарцуулсан зардлыг нөхөж олгохгүй.

3.2.6 Тухайн талбайд БХГ байгуулах сонгон шалгаруулалт явуулах тохиолдолд тухайн талбайд хийгдсэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан материалыг захиалга өгсөн компаниудад худалдах багц материал болгон бэлтгэнэ.

3.2.7 Тухайн талбайн багц материалын үнийг АМГТГ-ын даргын тушаалаар тогтоож, захиалга өгсөн компани бүрт сонгон шалгаруулалтын нэг үзүүлэлт болгон худалдана.

3.2.8 Энэхүү гэрээний 3.2.7-д заасан багц материал борлуулсан тохиолдолд орлогыг АМГТГ-т төвлөрүүлж, Талууд 50%, 50%-иар хуваан авна. Компанид ногдох хувийг нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.

3.2.9 Эрлийн ажилтай холбогдсон аливаа мэдээллийн нууцлалыг хадгална.

3.3 Компанийн эрх

3.3.1 Эрлийн ажил гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын холбогдох хууль, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

3.3.2 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд туслан гүйцэтгэгч ажиллуулж болно.

3.3.3 Ашигт малтмал, газрын тосны газрын өмчлөлд байгаа эрлийн ажил гүйцэтгэх талбайд хамаарах тайлан мэдээллийг үзэж судлах, шаардлагатай бол худалдан авч болно.

3.3.4 Эрэл хийсэн этгээд нь эрлийн ажлын үр дүнгийн тайланг төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулснаас хойш 60 хоногийн хугацаанд шатдаг занарын эрлийн талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах саналаа Газрын тосны тухай хуулийн 17.3-т заасны дагуу ирүүлнэ.

3.3.5 Энэхүү гэрээний 3.2.7-д заасан багц материал худалдагдсан тохиолдолд үнийг АМГТГ-аас нэхэмжлэх эрхтэй.


3.4 Компанийн үүрэг

3.4.1 Шатдаг занарын эрэл хийсэн этгээд нь эрлийн ажлын анхдагч материал, үр дүнгийн тайлан мэдээг төрийн захиргааны байгууллагад өгч дүгнэлт гаргуулах үүрэгтэй.

3.4.2 Эрлийн гэрээний эрх, үүргийг өөр этгээдийн нэр дээр шилжүүлэхийг хориглоно.

3.4.3 Гэрээний хавсралт В-д заасан ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгэнэ. Эрлийн ажлыг олон улсын газрын тосны аж үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг горимын дагуу мэргэжлийн түвшинд, цаг хугацаанд нь зохион байгуулж хэрэгжүүлнэ.

3.4.4 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдох гарах бүх зардлыг хариуцна.



3.4.5 Эрлийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг Ашигт малтмал, газрын тосны газарт тухай бүр танилцуулж байна.

3.4.6 Эрлийн ажилтай холбогдсон үйл ажиллагаанаас холбогдон гарах хариуцлагыг хүлээх бөгөөд аливаа хууль, дүрэм, журам стандарт зөрчсөний улмаас гарах бүх хохирлыг хариуцна.

3.4.7 Эрлийн ажилтай холбогдсон үйл ажиллагаанд байгаль орчинд халгүй, орчин үеийн дэвшилтэт техник, технологи хэрэглэж, газрын гадаргууд нөлөөлөх ажил хийх тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ. Хэрвээ гэрээг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд хор хохирол учруулбал хохирлыг барагдуулж, зохих нөхөн төлбөрийг төлнө.

3.4.8 Эрлийн ажил, арга аргачлал, техник, тоног төхөөрөмж, мэдээлэл, мэдээллийн боловсруулалт, үр дүнгийн тайлалтай танилцах, судлах зэрэгт Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох мэргэжилтнүүдийг биечлэн оролцуулна.

3.4.9 Эрлийн ажилд оролцох Ашигт малтмал, газрын тосны газраас томилогдсон мэргэжилтний бүх зардал (орон байр, хоол хүнс, тээврийн зардал) -ыг хариуцна.

3.4.10 Компани энэхүү гэрээний 3.1.3-т заасан АМГТГ-аас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ширхэг автомашин (жийп ангиллын туулах чадвар сайтай, шинэ, дизель хөдөлгүүртэй)-ыг худалдан авч АМГТГ-т буцалтгүйгээр өгнө.

3.4.11 Эрлийн ажилд холбогдсон үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг нэн тэргүүнд авч ажиллуулна.

3.4.12 Эрлийн ажлуудын мэдээллийг боловсруулж, тайлал хийж үр дүнгийн тайлан бичнэ. Хээрийн ажил дууссанаас хойш зургаан сарын хугацаанд судалгааны бүхий л мэдээлэл, баримт материал, үр дүнгийн тайлангийн нэг хувийг Ашигт малтмал, газрын тосны газарт үнэ төлбөргүй хүлээлгэн өгнө.

3.4.13 Энэхүү гэрээний 3.2.6-д заасан багц материалыг АМГТГ-ын шаардлагад нийцүүлэн бэлтгэж өгнө.

3.4.14 Ашигт малтмал, газрын тосны газрын 1-ээс доошгүй мэргэжилтнийг 2 хүртэл сарын хугацаагаар сургалт, семинар, үзэсгэлэнд хамруулах бөгөөд холбогдон гарах бүх зардлыг хариуцна.

Дөрөв. ОРЛОГО ХУВААХ

4.1 Талууд Эрлийн ажил гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан анхдагч материал, мэдээлэл, тайлан материал /боловсруулаагүй, боловсруулсан, тайлал хийсэн/ -ыг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн гуравдагч этгээдэд борлуулж болно.

4.2 Талууд эрлийн ажлын мэдээлэл, тайлан материалыг борлуулах талаар харилцан бичгээр мэдэгдэнэ.

4.3 Талууд худалдан авагчийн талаарх мэдээлэл болон үнийн саналыг харилцан бие биендээ хүргүүлнэ.

4.4 Эрлийн ажлын мэдээлэл, тайлан материалыг борлуулсан орлогоос тайлан материалыг зарж борлуулахтай холбогдон гарсан зардал болон орлогын татварын суутгалыг хийсний дараа үлдэх орлогыг талууд тавь (50%), тавин. (50%) хувиар хувааж авна.

Тав. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

ХУУЛЬЦАР ҮЙЛЭН
Хуулбар өгсөн

5.1 Эрлийн ажил гүйцэтгэх гэрээг 2 жилийн хугацаагаар байгуулав.
5.2 Гэрээний хугацаа: 2018 оны 02-р сарын 02-ны өдрөөс эхлэн 2020 оны 02-р сарын 02-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

5.2 Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.3 Гэрээг дараах үндэслэлээр дуусгавар болно:

а/ Гэрээний хугацаа дууссан;

б/ Хууль буюу энэхүү гэрээнд заасан үндэслэлээр гэрээг цуцалсан.

5.4 Гэрээг дараах үндэслэлээр цуцална.

5.4.1 Компани нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 180 хоногийн дотор төлөвлөгөөт ажлаа эхлээгүй, хавсралт "В"-д заасан хугацаанд гүйцэтгээгүй бол Ашигт малтмал, газрын тосны газар гэрээг цуцална. Энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

Зургаа. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1 Давагдашгүй хүчин зүйл, орон нутгийн эсэргүүцлийн улмаас Компани нь гэрээний үүргээ биелүүлээгүй бол үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд шаардагдах хугацааг нэмж тооцож болно.

6.2 Давагдашгүй хүчин зүйл, орон нутгийн эсэргүүцэл нь Талуудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд арилаагүй тохиолдолд энэхүү Гэрээг биелүүлээгүй гэж үзэхгүй.

6.3 Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тухай Талууд харилцан бичгээр мэдэгдэнэ.

Долоо. ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ

7.1 Компани эрлийн ажилтай холбогдсон үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, тогтоомжийг ноцтойгоор зөрчвөл Ашигт малтмал, газрын тосны газар зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд судалгааны ажлыг түр зогсооно.

7.2 Эрлийн ажил зогссон үед ажлын талбар дахь тоног төхөөрөмжүүдийг зохих ёсоор хамгаалж аюулгүй байдлыг хангах үүргийг компани хүлээнэ.

Найм. МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

8.1 Гэрээнд оролцогч талуудын хооронд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гомдлыг шүүхэд гаргаж болно.

8.2 Талууд нь энэхүү гэрээ болон Монгол Улсын холбогдох бусад хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсаны улмаас байгууллага, хувьд хүнд хохирол учруулсан бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

8.3 Талууд гэрээний үүргийг зөрчсөнөөс учирсан хохирлыг гэрээнд болон Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай тал нь нөхөн төлнө.

8.4 Эрлийн ажилтай холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгүүлэхээр сонгосон туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагааны улмаас учирсан бүх хохирлыг Компани хариуцна.

Ес. БУСАД

- 9.1 Энэхүү гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдэж, Талууд нэг, нэг хувийг хадгалах ба хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.
- 9.2 Хавсралт А, Б, В нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно.
- 9.3 Талуудын бичгээр өгөх мэдэгдэл нь факсаар явуулсан, шуудангаар дамжуулсан болон биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг хүлээн авсан тухай нотолгоотой тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 9.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж гэрээнд хавсаргаснаар хүчин төгөлдөр болно.
- 9.5 Гэрээнд Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 9.6 Талууд бичгээр өгөх мэдэгдлийг дараах хаягаар илгээнэ. Үүнд:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Ашигт малтмал, газрын тосны газар

Монгол улс, Улаанбаатар хот -15170,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3,
Засгийн газрын XII байр, баруун жигүүр
утас: (976) -51- 263741
факс: (976) -11-310370
Цахим шуудан: info@mrpam.gov.mn


“Эс Би Петролиум” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 2-р хороо
Сөүлийн гудамж 10/1,
Твин тауэр-1
утас: (976) -8888-8882

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА:

“Эс Би Петролиум” ХХК –ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ:




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР, “ЭС БИ ПЕТРОЛИУМ” ХХК-ИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН “ШАТДАГ ЗАНАР”-ЫН ЭРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ “А”

Энэхүү хавсралт “А” нь Ашигт малтмал, газрын тосны газар болон Эс Би Петролиум” ХХК-ийн хооронд 20¹⁶ оны 08-р сарын 08-ны өдөр байгуулсан Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

Эрлийн ажил нь Дундговь аймгийн аймгийн Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Сайнцагаан, Гурвансайхан сумдын нутаг дэвсгэрийг хамарна.

Талбайн зураг:



БАЙРСНИЛ ЗҮЙ		ЭРГЭДЛИЙН ТАЛБАЙ	
	Хэрэгтэйгээр хэрэглэгдэх		Шинэ хайгуулын талбай
	Холбоо		Шинэ хайгуулын талбай
	Тусламж (1:100,000)		Шинэ хайгуулын талбай
	Адаацаг тус		Шинэ хайгуулын талбай
	Суртал тус		Шинэ хайгуулын талбай

Огноо: 2016.09.20 Засварлагч: А.А. Ашигт малтмал газрын тосны газар: 2016



С.Б.А.

А.А.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР, "ЭС БИ ПЕТРОЛИУМ" ХХК-ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН "ШАТДАГ ЗАНАР"-ЫН ЭРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ
ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ "Б"

Энэхүү хавсралт "Б" нь Ашигт малтмал, газрын тосны газар болон "Эс Би Петролиум" ХХК-ийн хооронд 20¹⁸ оны 08-р сарын 08-ны өдөр байгуулсан Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.


Эрлийн ажил нь Дундговь аймгийн аймгийн Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Сайнцагаан, Гурвансайхан сумдын нутаг дэвсгэрийг хамарна.

Талбайн хэмжээ: 7195.86 км²

Талбайн солбицол:

№	Уртраг			Өргөрөг		
1	105	20	0	46	13	15
2	106	50	27	46	13	15
3	106	50	27	45	40	0
4	105	20	0	45	40	0

С.Б.А.А.



**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР, “ЭС БИ ПЕТРОЛИУМ” ХХК-ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН “ШАТДАГ ЗАНАР”-ЫН ЭРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ
ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ “В”**

Энэхүү хавсралт “В” нь Ашигт малтмал, газрын тосны газар болон “Эс Би Петролиум” ХХК-ийн хооронд 2018 оны 08 сарын 08-ны өдөр байгуулсан Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

ЭРЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Эрлийн ажлын төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэх хугацаа

Хүснэгт

д/д	Эрлийн ажлын төрөл, аргачлал	Ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, /ам.дол /	Нийт өртөг, /ам.дол/	Гүйцэтгэх хугацаа /сар/
1	Бэлтгэл ажил	1	5,000	5,000	1 дэх жилд
2	Эрэл зураглал	1	15,000	1,000	1 дэх жилд
3	Хүндийн хүчний судалгаа	600 ф.ц	30	18,000	1 дэх жилд
4	Соронзон судалгаа	400 т.км	20	8,000	1 дэх жилд
5	Чичирхийллийн судалгаа	30 т.км	3,500	105,000	1 дэх жилд
6	Лабораторийн задлан шинжилгээ, туршилт	1	10,000	10,000	1 дэх жилд
7	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	1	23,000	23,000	1 дэх жилд
Эхний жил, нийт				184,000	
	Өрөмдлөг, каротаж	1000 т.м	60	60,000	2 дахь жилд
	Лабораторийн задлан шинжилгээ, туршилт	1	20,000	20,000	2 дахь жилд
	Байгаль орчны менежмент	1	5,000	5,000	2 дахь жилд
	Үр дүнгийн тайлан боловсруулах, хэтийн төлвийн үнэлгээ өгөх	1	20,000	20,000	2 дахь жилд
Хоёрдахь жил, нийт				105,000	
Бүгд				289,000	